



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

УЛС ТӨРИЙН НАМЫН ТУХАЙ ХУУЛЬ, ТҮҮНИЙГ ДАГАЛДАН ГАРСАН ЖУРМЫН ХОЛБОГДОХ ЗААЛТ ТОДОРХОЙ БУС, УЯЛДАА ХАНГАЛТГҮЙ НЬ НАМУУДАД ОЛГОСОН ТӨРИЙН САНХҮҮЖИЛТИЙГ ЗОРИУЛАЛТ БУС ЗАРЦУУЛАХАД НӨЛӨӨЛСӨН БАЙНА.

АУДИТЫН СЭДЭВ: УЛС ТӨРИЙН НАМД ОЛГОСОН САНХҮҮЖИЛТ, ГҮЙЦЭТГЭЛД ГАРГАСАН ДҮГНЭЛТИЙГ МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД НЭГТГЭН ТАЙЛАГНАХ АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: САГ-2026/03/ШТА- НА

Цахим хуудас: www.audit.mn
Улаанбаатар хот
2026 он

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.

Санхүүгийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Н.Цэвэлмаа

Утас:261666, Цахим хаяг: tsevelmaan@audit.gov.mn

Тусгай чиг үүргийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Д.Баярсайхан

Утас:261671, Цахим хаяг: bayarsaikhand@audit.gov.mn

Санхүүгийн аудитын газрын аудитын менежер: И.Эрдэнэцэцэг

Утас:323266, Цахим хаяг: erdenetsetsegi@audit.gov.mn

Нийцлийн аудитын газрын аудитын менежер: П.Ундармаа

Утас:261839, Цахим хаяг: undarmaap@audit.gov.mn

Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор: Ш.Наран

Утас:323266, Цахим хаяг: naransh@audit.gov.mn

Санхүүгийн аудитын газрын аудитор: С.Билгүтэй

Утас:323266, Цахим хаяг: bilguteis@audit.gov.mn

Санхүүгийн аудитын газрын аудитор: Т.Нямсүрэн

Утас:323266, Цахим хаяг: nyamsurent@audit.gov.mn

Санхүүгийн аудитын газрын аудитор: Э.Цэлмэгбаяр

Утас:323266, Цахим хаяг: tselmegbayare@audit.gov.mn



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ТУШААЛ

2026 оны 06 сарын 09 өдөр

Дугаар А/66

Улаанбаатар хот

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх заалт, 20 дугаар зүйлийн 20.1, 20.2, 20.3, 20.4 дэх хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.1.9 дэх заалт, 29.3 дахь хэсэг, Улс төрийн намын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3, 39 дүгээр зүйлийн 39.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. “Улс төрийн намд олгосон санхүүжилт, гүйцэтгэлд гаргасан дүгнэлтийг Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэлд нэгтгэн тайлагнах аудитын тайлан”-г нэгдүгээр, аудитаар өгсөн албан шаардлагын жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталгаажуулсугай.

2. Аудитын тайланг Сонгуулийн ерөнхий хороонд хүргүүлэхийг Санхүүгийн аудитын газар (Н.Цэвэлмаа)-т даалгасугай.

3. Аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Сонгуулийн ерөнхий хороо (Д.Даваа-Очир)-нд даалгасугай.


4. Аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцон ажиллахыг Санхүүгийн аудитын газар (Н.Цэвэлмаа), Аудитын шийдвэрийн хэрэгжилтийн газар (Ч.Цэвэгдорж)-т тус тус үүрэг болгосугай.

5. Аудитын тайланг баталгаажуулснаас хойш 14 хоногт багтаан аудитын ажлын болон нотлох баримтаар хадгаламжийн нэгж үүсгэн Үндэсний аудитын газрын архивд хүлээлгэн өгөхийг Санхүүгийн аудитын газар (Аудитын менежер И.Эрдэнэцэцэг)-т үүрэг болгосугай.




С.МАГНАЙСҮРЭН

Монгол Улсын Ерөнхий аудиторын
2026 оны 06 сарын 09 ны өдрийн А/66
дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



Улс төрийн намд олгосон санхүүжилт, гүйцэтгэлд гаргасан дүгнэлтийг
Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэлд нэгтгэн тайлагнах аудитаар өгсөн албан
шаардлагын жагсаалт

№	Хэрэгжүүлэх байгууллага	Аудитад хамрагдагч	Шийдвэрийн нэр	Аудитын шийдвэр			
				Хүргүүлсэн хугацаа	Дугаар	Мөнгөн дүн (төгрөг)	Хэрэгжүүлэх хугацаа
1	Сонгуулийн Ерөнхий Хороо	Улс төрийн намууд	Албан шаардлага	2026.06.10	1484/АОМЗН САГ - 2026/03/ ИЛТА - НА	191,581,767.00	2026.12.01
Нийт дүн						191,581,767.00	



Агуулга

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	2
ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ	2
Аудит хийх үндэслэл, бүрэн эрх.....	3
Аудитын зорилт.....	3
Аудитын хамрах хүрээ.....	3
Аудитын арга зүй	3
Ерөнхий мэдээлэл	3
УЛС ТӨРИЙН НАМУУДАД ОЛГОСОН ТӨРИЙН САНХҮҮЖИЛТИЙН ЗАРЦУУЛАЛТЫН ЗАРДЛЫН АНГИЛАЛ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ ТОДОРХОЙГҮЙ, ХУУЛЬ, ЖУРМЫН ЗААЛТ УЯЛДААГҮЙ, ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙХ ЧИГ ҮҮРЭГ ДАВХАРДАЖ БАЙНА.	5
1. Төрийн санхүүжилт авах эрх бүхий намын бодитой тоо, судалгаанд үндэслэн төсвийн төсөл боловсруулаагүй, Улсын Их Хурлын ээлжит, эсхүл ээлжит бус сонгуулиар сонгогчийн жагсаалтад бүртгэгдсэн нийт сонгогчийн тоонд үндэслэн төсвийн төслийг боловсруулсан байна.	5
2. Улс төрийн намд төрөөс олгосон санхүүжилтээс нийт 191.5 сая төгрөгийг зориулалтын дагуу зарцуулаагүй байна.	6
3. Аудитын хуулийн этгээд нь төрийн санхүүжилтийн зарцуулалт хууль тогтоомжид нийцсэн эсэхийг дүгнэж, тайлагнаагүй байна.	7
4. Сонгуулийн ерөнхий хороо улс төрийн намд олгох төрийн санхүүжилтийг хуульд заасны дагуу зарцуулж, тайлагнасан эсэхийг дүгнээгүй, чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй байна.	7
5. Сонгуулийн ерөнхий хорооны хяналтын шалгуур үзүүлэлт тодорхойгүй, авч хэрэгжүүлсэн арга хэмжээг үнэлэх боломжгүй байна.	8
ДҮГНЭЛТ	10
ЗӨВЛӨМЖ	11
Шалгагдагч байгууллагаас ирүүлсэн санал, тайлбар	14
ХАВСРАЛТ 1	16
Албан шаардлага.....	19

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АН	Ардчилсан нам
АХЭ	Аудитын хуулийн этгээд
ИЗНН	Иргэний зориг ногоон нам
МАН	Монгол Ардын нам
МНН	Монголын Ногоон нам
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
МУНН	Монголын Уламжлалын Нэгдсэн нам
МҮАН	Монголын Үндэсний Ардчилсан нам
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
СЕХ	Сонгуулийн ерөнхий хороо
ТАБ	Төрийн аудитын байгууллага
УТНТ	Улс төрийн намын тухай
УИХ	Улсын Их Хурал
ХБ	Хөгжлийн бэрхшээлтэй
ХҮН	ХҮН нам
ШН	Шинэ нам

ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1	Төрийн санхүүжилт авсан улс төрийн намын 2025 оны санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийн төрөл
Хүснэгт 2	Төрөөс намуудад олгосон санхүүжилт
Хүснэгт 3	УИХ-ын ээлжит сонгуулийн дараагийн жил зөвхөн нэг удаа олгох санхүүжилтийг авах эрх үүсээгүй улс төрийн намууд
Хүснэгт 4	Төрийн санхүүжилтийн хуульд заасан хувиар зарцуулсан байдал
График 1	Улс төрийн намын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил

Улс төрийн намд олгосон санхүүжилт, гүйцэтгэлд гаргасан дүгнэлтийг Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэлд нэгтгэн тайлагнах аудитын тайлан

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд Улс төрийн намын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн зүйлийн 31.3, 39 дүгээр зүйлийн 39.4, 39.5 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2025 оны 25 дугаар тогтоол, МУЕА-ын 2025 оны А/179 дүгээр тушаалыг тус тус үндэслэн аудитыг гүйцэтгэлээ.

Аудитын зорилт

Улс төрийн намд олгох төрийн санхүүжилт, түүний зарцуулалт, тайлагналд аудит хийж, дүгнэлт өгөхөд аудитын зорилт оршино.

Дээрх зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэв. Үүнд:

- Улс төрийн намын санхүүжилтийн хуваарилалт хууль тогтоомжид нийцсэн эсэх;
- Төрөөс олгосон санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулсан эсэх;
- Улс төрийн намын санхүүжилтийн зарцуулалт, түүний тайлагналд Сонгуулийн ерөнхий хорооноос хяналт хэрэгжүүлсэн эсэх.

Аудитын хамрах хүрээ

Улс төрийн намд олгосон төрийн санхүүжилт, түүний гүйцэтгэлд дүгнэлт гаргах зорилгоор Аудитын хуулийн этгээдийн хэрэгжүүлсэн аудитын горим, сорил, гаргасан дүгнэлт, СЕХ-ны төрийн санхүүжилтийн хэмжээг тогтоосон эрх зүйн баримт бичиг, мөн 2026 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 3/187, 2026 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн 1/201 дүгээр албан бичгүүдийн хавсралтаар ирүүлсэн улс төрийн намуудын үйл ажиллагааны товч тайлан, аудитлагдсан санхүүгийн тайлан, СЕХ-ны нэгтгэсэн тайлан, төрийн санхүүжилтийн зарцуулалттай холбоотой анхан шатны баримт материал болон санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой бусад мэдээллийг аудитад хамруулав.

Аудитын арга зүй

Аудитыг АДБООС 100-400, 4000, 4001, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020, MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандарт, МУЕА-ын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, 2021 оны А/71 дүгээр тушаалаар баталсан “Нийцлийн аудитын заавар, аргачлал”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт хийх арга зүйг ашиглан гүйцэтгэж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Ерөнхий мэдээлэл

Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуульд 19 нам, 2 эвсэл болон бие даан нэр дэвшигчид оролцож, нийт 1,341 нэр дэвшигч өрсөлдсөнөөс 372 нь жагсаалтаар, 969 нь тойрогт нэр дэвшсэн байна. Сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдсэн 2,089,949 сонгогчийн 73.2 хувь нь сонгуульд оролцжээ.¹

УТНТ хууль 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэн нийт сонгогчдын нэг ба түүнээс дээш хувийн санал авсан, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн хууль тогтоомжид заасан нэр дэвшигчийн хүйсийн квотоос илүү нэр дэвшүүлсэн эмэгтэй улс төрчийн тоо болон хөгжлийн бэрхшээлтэй нэр дэвшигчийн тоог үндэслэн олгох төрийн санхүүжилт авах болзлыг 9 улс төрийн нам хангасан байна.

СЕХ-оос зохион байгуулсан тендерт шалгарсан 5 аудитын хуулийн этгээд 29 улс төрийн намын 2025 оны санхүүгийн тайланд баталгаажуулах аудитыг гүйцэтгэж, санал дүгнэлт өгсөн байна.

¹ Монгол Улсын Их Хурлын цахим хуудас /<https://www.parliament.mn/nn/62973/>.

Улс төрийн намд олгосон санхүүжилт, гүйцэтгэлд гаргасан дүгнэлтийг Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэлд нэгтгэн тайлагнах аудитын тайлан

Дээрх улс төрийн намуудаас төрийн санхүүжилт авах болзол хангасан 9 намын 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудитын хуулийн этгээд аудит хийж, 6 намд өөрчлөлтгүй, 3 намд хязгаарлалттай санал дүгнэлт өгсөн байна.


Хүснэгт 1. Төрөөс санхүүжилт авсан улс төрийн намын 2025 оны санхүүгийн тайланд аудитын хуулийн этгээдийн өгсөн дүгнэлт

№	Улс төрийн намын нэр	Дүгнэлтийн хэлбэр	Дүгнэлт өгсөн АХЭ-ийн нэр
1	Монгол Ардын нам	Өөрчлөлтгүй	Миндүг аудит ХХК
2	Ардчилсан нам	Өөрчлөлтгүй	Миндүг аудит ХХК
3	ХҮН нам	Өөрчлөлтгүй	Өлзийт Экаунт аудит ХХК
4	Монголын Ногоон нам	Хязгаарлалттай	Аав Ээжийн тэнгэрлэг буян аудит ХХК
5	Монголын Уламжлалын Нэгдсэн нам	Өөрчлөлтгүй	Аав Ээжийн тэнгэрлэг буян аудит ХХК
6	Монголын Үндэсний Ардчилсан нам	Өөрчлөлтгүй	Өлзийт Экаунт аудит ХХК
7	Иргэний Зориг Ногоон нам	Хязгаарлалттай	Голден Пэйж аудит ХХК
8	Шинэ нам	Хязгаарлалттай	Голден Пэйж аудит ХХК
9	Үнэн ба Зөв нам	Өөрчлөлтгүй	Эвиденсе аудит ХХК

Аудитын хуулийн этгээд төрийн санхүүжилт авсан улс төрийн намуудын санхүүгийн тайлан баталгаажуулах аудитаар нийт 824.6 сая төгрөгийн 50 алдаа, зөрчил илэрсэнд 53.2 сая төгрөгийн 11 алдааг залруулж, 24.5 сая төгрөгийн 2 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 685.4 сая төгрөгийн 20 зөрчилд зөвлөмж өгч, нийцлийн аудитаар илэрсэн 3 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 61.5 сая төгрөгийн 14 зөрчилд зөвлөмж өгсөн байна.

График 1. Улс төрийн намын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил

/сая төгрөгөөр/



Улс төрийн намд олгосон санхүүжилт, гүйцэтгэлд гаргасан дүгнэлтийг Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэлд нэгтгэн тайлагнах аудитын тайлан

УЛС ТӨРИЙН НАМУУДАД ОЛГОСОН ТӨРИЙН САНХҮҮЖИЛТИЙН ЗАРЦУУЛАЛТЫН ЗАРДЛЫН АНГИЛАЛ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ ТОДОРХОЙГҮЙ, ХУУЛЬ, ЖУРМЫН ЗААЛТ УЯЛДААГҮЙ, ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙХ ЧИГ ҮҮРЭГ ДАВХАРДАЖ БАЙНА.

1. Төрийн санхүүжилт авах эрх бүхий намын бодитой тоо, судалгаанд үндэслэн төсвийн төсөл боловсруулаагүй, Улсын Их Хурлын ээлжит, эсхүл ээлжит бус сонгуулиар сонгогчийн жагсаалтад бүртгээгдсэн нийт сонгогчийн тоонд үндэслэн төсвийн төслийг боловсруулсан байна.

1.1 УТНТ хуулийн 27 дугаар зүйлийн 27.12²-т заасны дагуу 2025 онд намуудад олгох төрийн санхүүжилтийг Сонгуулийн төв байгууллагын төсвийн багцад суулгаж, батлуулахаар хуульчилсан байна.

1.2 СЕХ нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.3³-т заасны дагуу төсвийн төслийн саналд улс төрийн намын санхүүжилтэд олгох 9,655.6 сая төгрөгийн зардлыг тооцоолсон нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 74 дүгээр зүйлийн 74.5⁴ дахь хэсэгт заасны дагуу СЕХ-ны 2024 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 191 дүгээр тогтоолоор батлагдсан Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцох шийдвэр, сонгуулийн үр дүнд үндэслэж бодитой төлөвлөөгүй байна.

1.3 УИХ-аас 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай” хуульд СЕХ-ны даргын төсөвт улс төрийн намуудад олгох санхүүжилтийг 8,690.0 сая төгрөгөөр баталж, төсвийн тодотголоор 7,171.6 сая төгрөг болгож, 1,518.4 сая төгрөгөөр бууруулан баталжээ.

1.4 СЕХ-ны 2025 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн 05 дугаар тогтоолоор төрийн санхүүжилтийн хэмжээг эцэслэн тогтоож, СЕХ-ны даргын 2025 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн А/14, 2025 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн А/32 дугаар захирамжид тус тус үндэслэн улс төрийн 7 намд 6,954.9 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Хүснэгт 2. Төрөөс намуудад олгосон санхүүжилт

/сая төгрөгөөр/

№	Намын нэр	Эвслийн нэр	29.9-т заасны дагуу олгосон санхүүжилт		
			27.5-т заасны дагуу олгох	27.7-т /квот болон ХБ/	Нийт
1	Монгол Ардын нам		2,803.3	16.5	2,819.8
2	Ардчилсан нам		2,140.1	33.0	2,173.1
3	ХҮН нам		630.7	363.0	993.7
4	Иргэний зориг ногоон нам		306.9	148.5	455.4
5	Монголын Ногоон нам	Үндэсний эвсэл	176.0	-	176.0
6	Монголын Үндэсний Ардчилсан нам		24.4	-	24.4
7	Шинэ Нам	Шинэ Нэгдсэн Эвсэл	230.0	82.5	312.5
8	Монголын Уламжлалын Нэгдсэн нам		-	-	-
9	Үнэн ба Зөв нам		-	-	-
Нийт дүн			6,311.4	643.5	6,954.9

Эх сурвалж: СЕХ-ны 2025 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн 05 дугаар тогтоол

1.5 Улс төрийн намууд нь төрийн санхүүжилтийг авах хүсэлтийг сонгуулийн төв байгууллагад ирүүлэхдээ хуульд заасан зориулалтаар зарцуулах төсөв, төлөвлөгөөг баталгаажуулж ирүүлдэггүй байна.

1.6 СЕХ-оос нэр дэвшигчийн хүйсийн квотоос илүү нэр дэвшүүлсэн эмэгтэй улс төрчийн тоо болон ХБ нэр дэвшигчийн тоог үндэслэн олгох төрийн санхүүжилтийг Үндэсний эвсэл (МНН,

² Намд олгох төрийн санхүүжилтийг жил бүр сонгуулийн төв байгууллагын төсвийн багцад суулгаж, батлуулна;

³ Төсвийн ерөнхийлөн захирагч жилийн төсвийн саналаа жил бүрийн 07 дугаар сарын 25-ны дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, төрийн аудитын байгууллага, Улсын Их Хуралд хүргүүлж, нийтэд ил тод мэдээлэх;

⁴ Сонгуулийн ерөнхий хороо нь сонгуулийн дүн, Монгол Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцсон тухай шийдвэрийг сонгууль дууссанаас хойш 15 хоногийн дотор Улсын Их Хурал болон Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлнэ.

Улс төрийн намд олгосон санхүүжилт, гүйцэтгэлд гаргасан дүгнэлтийг Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэлд нэгтгэн тайлагнах аудитын тайлан

МҮАН) 132.0 сая төгрөг, Монголын Үнэн ба Зөв нам 115.5 сая төгрөг авахаар тооцоолсон байна. Гэвч дээрх эвсэлд багтсан намуудын 2024 оны орлогын хэмжээ болон Үнэн ба Зөв намын татгалзал нь тус санхүүжилтийг олгох нөхцөлийг хангаагүй буюу УТНТ хуулийн 27 дугаар зүйлийн 27.7⁵-д заасны дагуу Улсын Их Хурлын ээлжит сонгуулийн дараах жил зөвхөн нэг удаа олгох хуульд заасан хугацааны хязгаарлалтад хамаарах тул дараагийн УИХ-ын ээлжит сонгууль хүртэл тус санхүүжилтийг авах эрх үүсэхээргүй байна.

Хүснэгт 3. УИХ-ын ээлжит сонгуулийн дараагийн жил зөвхөн нэг удаа олгох санхүүжилтийг авах эрх үүсээгүй улс төрийн намууд

/сая төгрөгөөр/

№	Намын нэр	Эвслийн нэр	Хүйсийн квотоос илүү нэр дэвшүүлсэн эмэгтэй улс төрчийн тоо	ХБ нэр дэвшигчийн тоо	Хуулийн 27.6.5-т заасны дагуу /660.000*25/
1	Монголын Ногоон нам	Үндэсний эвсэл	8	-	132.0
2	Монголын Үндэсний Ардчилсан нам				
3	Үнэн ба Зөв нам		5	2	115.5
Нийт дүн			13	2	247.5

Эх сурвалж: СЕХ-оос ирүүлсэн төрийн санхүүжилтийн тооцоолол

2. Улс төрийн намд төрөөс олгосон санхүүжилтээс нийт 191.5 сая төгрөгийг зориулалтын дагуу зарцуулаагүй байна.

2.1 Төрийн санхүүжилт авсан 7 улс төрийн намууд УТНТ хуулийн 26.3⁶-т заасан зориулалтаар дор дурдсан хувиар зарцуулсан байна. Хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 4. Төрийн санхүүжилтийн хуульд заасан хувиар зарцуулсан байдал

/сая төгрөгөөр/

№	Намын нэр	26.3.1-д 20-оос доошгүй		26.3.2-т 15-аас доошгүй		26.3.3-т 15-аас доошгүй		Нийт	
		Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
1	Монгол Ардын нам	564.5	20.0	424.1	15.0	423.1	15.0	1,411.6	50.0
2	Ардчилсан нам	312.9	14.4	313.9	14.4	787.9	36.3	1,414.7	65.1
3	ХҮН нам	199.7	20.1	150.7	15.2	149.6	15.1	500.0	50.4
4	Иргэний Зориг Ногоон нам	61.0	13.4	92.0	20.2	77.0	16.9	230.0	50.5
5	Шинэ нам	82.5	26.4	60.9	19.5	61.5	19.7	204.8	65.6
6	Монголын Ногоон нам	35.2	20.0	26.4	15.0	35.0	19.9	96.6	55.1
7	Монголын Үндэсний Ардчилсан нам	5.9	24.3	3.5	14.3	4.2	17.2	13.6	55.8
Дүн		1,261.6	18.1	1,071.5	15.4	1,538.2	22.1	3,871.3	55.6

Эх сурвалж: Улс төрийн намын 2025 оны санхүүгийн тайлан баталгаажуулсан хараат бус АХЭ-ийн дүгнэлт, тайлан

2.2 Төрийн санхүүжилт авсан 7 улс төрийн нам нь УТНТ хуулийн 26 дугаар зүйлийн 26.3-т заасан зориулалтаар эмэгтэй, ахмад, залуу, ХБ иргэд зэрэг нийгмийн бүлгүүдийн улс төрийн оролцоог дэмжих, сургаж бэлтгэхэд 1,261.6 сая төгрөг буюу 18.1 хувь, намын гишүүдийн болон иргэдийн улс төрийн боловсролыг дээшлүүлэх, ардчилал, хүний эрхийн үнэт зүйлийг нийтэд таниулахад 1,071.5 сая төгрөг буюу 15.4 хувь, намын хөтөлбөр, бодлого боловсруулахад чиглэсэн судалгаа хийх, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, намын

⁵ Сонгуулийн төв байгууллага энэ хуулийн 27.3-т заасан шаардлагыг хангасан намд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн хууль тогтоомжид заасан нэр дэвшигчийн хүйсийн квотоос илүү нэр дэвшүүлсэн эмэгтэй улс төрчийн тоог болон хөгжлийн бэрхшээлтэй нэр дэвшигчийн тоог энэ хуулийн 27.6.5-д заасан дүнгээр үржүүлсэнтэй тэнцэх төрийн санхүүжилтийг тухайн ээлжит сонгуулийн дараагийн жил зөвхөн нэг удаа олгоно;

⁶ Намд олгох жил бүрийн төрийн санхүүжилтийн дараах хувийг доор дурдсан зориулалтаар зарцуулна.

Улс төрийн намд олгосон санхүүжилт, гүйцэтгэлд гаргасан дүгнэлтийг Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэлд нэгтгэн тайлагнах аудитын тайлан

дотоод ардчиллыг хөгжүүлэхэд 1,538.2 сая төгрөг буюу 22.1 хувь, нийт 3,871.3 сая төгрөг буюу 55.6 хувийг хуульд заасан зориулалтаар зарцуулсан байна.

2.3 Төрөөс олгосон санхүүжилтээс нийт **191.5** сая төгрөгийг зориулалтын дагуу зарцуулаагүй зөрчил илэрсэн. Үүнд:

- *Анхан шатны баримтгүй 85.9 сая төгрөгийн ажил гүйлгээг бүртгэж, тайлагнасан; (МАН 51.6 сая төгрөг, МҮАН 24.4 сая төгрөг, ИЗНН 9.9 сая төгрөг)*
- *Төрийн санхүүжилтийн эх үүсвэрээс 61.5 сая төгрөгөөр сургалт зохион байгуулах, медиа контент бүтээлгэх зардалд зарцуулахаар гүйцэтгэгч байгууллагад шилжүүлсэн боловч намын дүрмээ шинэчлэн батлуулаагүй шалтгаанаар гэрээний хэрэгжилтийг хангаж ажиллаагүй; (МНН 61.5 сая төгрөг)*
- *Бэлэг дурсгал, урлаг соёлын арга хэмжээний зардалд 44.1 сая төгрөгийг зарцуулсан (ХҮН 44.1 сая төгрөг);*

2.4 Улс төрийн намууд төрийн санхүүжилтээс ажиллагсдын цалингийн зардалд 2,281.0 сая төгрөг, түрээсийн төлбөр, ашиглалтын зардалд 215.0 сая төгрөг, шуудан холбооны зардалд 31.8 сая төгрөг, бичиг хэргийн зардалд 17.9 сая төгрөг, албан томилолт, төлбөр хураамж, тээврийн зардалд 20.2 сая төгрөг, зөвлөх үйлчилгээний зардалд 118.1 сая төгрөг, хэвлэл мэдээллийн зардалд 64.0 сая төгрөг, хангамжийн зардалд 20.9 сая төгрөг, хөрөнгө худалдан авахад 126.2 сая төгрөг, бусад зардалд 188.4 сая төгрөг, нийт **3,083.5** сая төгрөг буюу санхүүжилтийн 44.4 хувийг үйл ажиллагааны зардалд зарцуулсан байна. (МАН 1,408.2 сая төгрөг, АН 758.4 сая төгрөг, ХҮН 493.7 сая төгрөг, ИЗНН 225.4 сая төгрөг, ШН 107.6 сая төгрөг, МНН 79.4 сая төгрөг, МҮАН 10.8 сая төгрөг)

2.5 Дээрх 3,083.5 сая төгрөгийг үйл ажиллагааны зардалд зарцуулсан нь УТНТ хуулийн 26 дугаар зүйлийн 26.3⁷, 26.4⁸ дэх хэсэгт заасантай нийцэхгүй байна.

3. Аудитын хуулийн этгээд нь төрийн санхүүжилтийн зарцуулалт хууль тогтоомжид нийцсэн эсэхийг дүгнэж, тайлагнаагүй байна.

3.1 СЕХ нь УТНТ хуульд заасны дагуу намын санхүүгийн тайланг баталгаажуулах зорилгоор аудитын хуулийн этгээдээр хараат бусаар дүгнэлт гаргуулах ажлыг зохион байгуулж, 5 АХЭ-г сонгон шалгаруулсан байна.

3.2 СЕХ-ноос баталсан АХЭ-ээр аудит хийлгэх ажлын даалгаварт “...шаардлагатай тохиолдолд төлбөрийн акт тогтоох, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх талаар албан шаардлага өгнө” гэж АХЭ-дэд албан шаардлага, төлбөрийн акт тогтоох эрх бүхий захиргааны акт гаргахаар тусгаж, аудитын хуулийн этгээдийн эрх, үүрэгт үл хамаарах эрх хэмжээ олгосон байна.

3.3 АХЭ нь батлагдсан ажлын даалгаврын хүрээнд төрийн санхүүжилтийн зарцуулалтад горим сорил хэрэгжүүлж, улс төрийн 4 намд зөвлөмж өгч, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар дурдсан боловч төрийн санхүүжилтийн зарцуулалтыг зориулалтын дагуу зарцуулсан эсэх, орлогын эх үүсвэрээр нь зарцуулалтыг ялгаж аудитлаагүй байна.

4. Сонгуулийн ерөнхий хороо улс төрийн намд олгох төрийн санхүүжилтийг хуульд заасны дагуу зарцуулж, тайлагнасан эсэхийг дүгнээгүй, чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй байна.

4.1 СЕХ нь Сонгуулийн төв байгууллагын тухай хууль болон УТНТ хуульд заасан чиг үүргийн хүрээнд төрийн санхүүжилт авсан улс төрийн 7 намын 2025 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, үйл ажиллагааны товч тайлан болон 6 намын санхүүгийн тайланд хийсэн хараат бус аудитын хуулийн этгээдийн дүгнэлт, тайланг хянаж нэгтгэсэн боловч тус тайланд төрийн санхүүжилтийн зарцуулалтыг УТНТ хуулийн 26 дугаар зүйлийн

⁷ Намд олгох жил бүрийн төрийн санхүүжилтийн дараах хувийг доор дурдсан зориулалтаар зарцуулна;

⁸ Энэ хуулийн 26.3.1, 26.3.2, 26.3.3-т заасан зорилтот санхүүжилт тус бүрийн гуравны нэгээс доошгүйг намын бодлогын судалгааны байгууллагын үйл ажиллагаанд зарцуулна.

Улс төрийн намд олгосон санхүүжилт, гүйцэтгэлд гаргасан дүгнэлтийг Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэлд нэгтгэн тайлагнах аудитын тайлан

26.3.1⁹, 26.3.2¹⁰, 26.3.3¹¹, 26.4¹²-т заасан зарцуулбал зохих доод хэмжээнд хүрч зарцуулсан эсэхийг ангилан тайлагнаагүй байна.

4.2 Нэр бүхий хоёр нам нь төрийн санхүүжилтийг УТНТ хуулийн 26.3.1-д “төрийн санхүүжилтийн 20-оос доошгүй хувийг эмэгтэй, ахмад, залуу, хөгжлийн бэрхшээлтэй иргэд зэрэг нийгмийн бүлгүүдийн улс төрийн оролцоог дэмжих, сургаж бэлтгэх”, 26.3.2-т “төрийн санхүүжилтийн 15-аас доошгүй хувийг намын гишүүдийн болон иргэдийн улс төрийн боловсролыг дээшлүүлэх, ардчилал, хүний эрхийн үнэт зүйлийг нийтэд таниулах” гэж заасны дагуу зарцуулбал зохих доод хязгаарт хүрээгүй, 163.9 сая төгрөгийг дутуу зарцуулсныг хараат бус АХЭ болон СЕХ хянаж дүгнээгүй байна. /АН 133.8 сая төгрөг, ИЗНН 30.1 сая төгрөг/

4.3 Шилэн дансны тухай хууль, УТНТ хууль, СЕХ-ны 2024 оны 209 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Намд төрийн санхүүжилт олгох, шууд бус дэмжлэгийг шийдвэрлэх, намын санхүү болон үйл ажиллагааг тайлагнах, мэдээлэх, хяналт тавих журам”-д улс төрийн нам санхүүгийн тайлан, үйл ажиллагааны товч тайлан зэрэг нийтэд ил тод мэдээлэх мэдээллийн талаар зохицуулалтыг заасан боловч улс төрийн намууд санхүүжилтийн төсөвт өртөг, зарлага, санхүүжилтийн мэдээлэл, тайланг шилэн дансанд мэдээлээгүй, цахим системд бүртгэлгүй байна.

4.4 Иймд СЕХ төрийн санхүүжилтийн зарцуулалтад хяналтыг сайжруулах, улс төрийн намуудыг шилэн дансны цахим хуудас хөтлүүлж, ил тод мэдээлэх зэрэг хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах шаардлагатай байна.

5. Сонгуулийн ерөнхий хорооны хяналтын шалгуур үзүүлэлт тодорхойгүй, авч хэрэгжүүлсэн арга хэмжээг үнэлэх боломжгүй байна.

5.1 СЕХ нь УТНТ хуульд заасны дагуу намуудын 2025 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, үйл ажиллагааны товч тайлан болон мэдээллийн ил тод байдлыг хэрэгжилтийг хянан “Улс төрийн намын тухай хууль”, “Улс төрийн намын санхүүгийн тайлангийн бүтэц, тайлагнах журам”, “Намд төрийн санхүүжилт олгох, шууд бус дэмжлэгийг шийдвэрлэх, намын санхүү болон үйл ажиллагааг тайлагнах, мэдээлэх, хяналт тавих журам”-ын зарим заалтын хэрэгжилтийг хангалтгүй гэж дүгнэсэн байна.

5.2 Төрийн санхүүжилтийн зарцуулалт, түүний тайлагналыг хянах шалгуур үзүүлэлт тодорхойгүй, хуулийг дагаж мөрдөх журам, заавар, хуулийн нийцэл уялдаагүй, ойлголтын зөрүүтэй, төрийн санхүүжилтийг бусад эх үүсвэрээс тусад нь салгаж тайлагнуулаагүй зэрэг цаашид засаж залруулах зөрчилтэй асуудлууд байна.

5.3 УТНТ хуульд улс төрийн намын санхүүгийн тайланд хараат бус АХЭ-ээр дүгнэлт гаргуулах, СЕХ-оос тайланг хүлээн авч хянах, ТАБ-аас төрийн санхүүжилтийн зарцуулалт, тайлагналд дүгнэлт гаргах чиг үүргийг тус тусдаа байхаар хуульчилсан нь хяналт, шалгалтын чиг үүргийн давхардал үүсгэх нөхцөлийг бүрдүүлж байна.

5.4 Энэ нь Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.7¹³-д заасантай нийцэхгүй байна.

5.5 Иймд төрийн хяналт шалгалтын тогтолцооны уялдаа холбоо, үр ашгийг дээшлүүлж, чиг үүргийн давхардлыг арилгах чиглэлээр хуулийн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагатай байна.

⁹ Төрийн санхүүжилтийн 20-оос доошгүй хувийг эмэгтэй, ахмад, залуу, хөгжлийн бэрхшээлтэй иргэд зэрэг нийгмийн бүлгүүдийн улс төрийн оролцоог дэмжих, сургаж бэлтгэх;

¹⁰ төрийн санхүүжилтийн 15-аас доошгүй хувийг намын гишүүдийн болон иргэдийн улс төрийн боловсролыг дээшлүүлэх, ардчилал, хүний эрхийн үнэт зүйлийг нийтэд таниулах;

¹¹ төрийн санхүүжилтийн 15-аас доошгүй хувийг намын хөтөлбөр, бодлого боловсруулахад чиглэсэн судалгаа хийх, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, намын дотоод ардчиллыг хөгжүүлэх;

¹² Энэ хуулийн 26.3.1, 26.3.2, 26.3.3-т заасан зорилтот санхүүжилт тус бүрийн гуравны нэгээс доошгүйг намын бодлогын судалгааны байгууллагын үйл ажиллагаанд зарцуулна.

¹³ Хяналт шалгалтыг давхардуулахгүй бөгөөд төрийн эрх бүхий байгууллагаас хийсэн шинжилгээний дүн, дүгнэлтийг хяналт шалгалтыг хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага харилцан хүлээн зөвшөөрөх.

Улс төрийн намд олгосон санхүүжилт, гүйцэтгэлд гаргасан дүгнэлтийг Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэлд нэгтгэн тайлагнах аудитын тайлан

5.6 УТНТ хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3¹⁴, 39 дүгээр зүйлийн 39.4¹⁵, 39.5¹⁶ дахь хэсгүүдэд Төрийн аудитын байгууллагын аудитын хамрах хүрээ, дүгнэлт гаргах болон тайлагнах хугацааг өөр өөр байдлаар хуульчилсан нь төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх талаар дүгнэлт гаргах ТАБ-ын эрх, үүрэг, хариуцлагын хүрээг тодорхой бус болгож байна.

¹⁴ Төрийн аудитын байгууллага нь сонгуулийн төв байгууллагын төсвийн багцад туссан намд олгох төрийн санхүүжилт, түүний зарцуулалт, тайлагналд Төсвийн тухай хуульд заасан цаглаврын дагуу аудит хийж, дүгнэлт гаргана;

¹⁵ Энэ хуульд заасны дагуу намын санхүүгийн тайланг сонгуулийн төв байгууллага хүлээн авч хянаад жил бүрийн 04 дүгээр сарын 05-ны өдрийн дотор Төрийн аудитын байгууллагад дүгнэлт гаргуулахаар хүргүүлнэ;

¹⁶ Төрийн аудитын байгууллага төрөөс намд олгосон санхүүжилт, гүйцэтгэлд гаргасан дүгнэлтийг жил бүрийн төсвийн гүйцэтгэлийн тайланд тусган тайлагнана.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Улс төрийн нэр бүхий 7 намд 6,954.9 сая төгрөгийн санхүүжилт олгосны 191.5 сая төгрөгийг зориулалтын дагуу зарцуулаагүй байна;
2. Сонгуулийн ерөнхий хороо нь улс төрийн намд олгосон төрийн санхүүжилтийг хуульд заасны дагуу зарцуулсан эсэхэд хяналт тавих чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй байна;
3. Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.11 дэх хэсэгт нийцүүлэн улс төрийн намуудад шилэн дансны нэгдсэн цахим хуудас хөтлүүлж, ил тод мэдээлэх хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

Сонгуулийн ерөнхий хороонд:

1. Улс төрийн намын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3, 26.4-т заасан улс төрийн намд олгож байгаа санхүүжилтийг зарцуулах хувь, зардлын ангилал, шалгуур үзүүлэлт, бүртгэл тайлагналыг тодорхой болгох ажлыг зохион байгуулах, холбогдох журам, маягыг хуульд нийцүүлэх;
2. Улс төрийн намд олгосон санхүүжилтийг анхан шатны баримт, цахим төлбөрийн баримтад үндэслэн хуульд заасан зориулалтаар зарцуулах, бүртгэл, тайланд бүрэн тусгах;
3. Төрийн санхүүжилт авч байгаа нам, эвслийн шилэн дансны нэгдсэн цахим хуудас хөтлүүлэх, ил тод мэдээлүүлэх ажлыг зохион байгуулж, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах.

**МОНГОЛ УЛСЫН
СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРОО**

Засгийн газрын XI байр, Ж.Самбуугийн гудамж 11,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15141

Утас: 26 09 75, Цахим шуудан: gecm@gec.gov.mn,

Цахим хуудас: www.gec.gov.mn

2026.06.05 № 1/347

танай _____-ны № _____-т

Тайлбар хүргүүлэх тухай

Танай 2026 оны 06 дугаар сарын 03-ны өдөр тус Хороонд ирүүлсэн тайлангийн төсөлтэй танилцаад дараах санал, тайлбарыг гаргаж байна.

Улс төрийн намын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.4, 39 дүгээр зүйлийн 39.4, 39.5, Сонгуулийн ерөнхий хорооны 2024 оны 209 дүгээр тогтоолоор батлагдсан “Намд төрийн санхүүжилт олгох, шууд бус дэмжлэгийг шийдвэрлэх, намын санхүү болон үйл ажиллагааг тайлагнах, мэдээлэх, хяналт тавих журам”-ын 8 дугаар зүйлийн 8.1, 8.2-т тус тус заасны дагуу Төрийн аудитын байгууллага нь намд олгох төрийн санхүүжилтийг тогтоосон байдал, түүний зарцуулалтад хяналт тавихаар хуульчилсан байна. Гэтэл танай тайлангийн төсөлд Сонгуулийн ерөнхий хорооны хяналтын ажиллагаанд аудит хийж дүгнэлт, зөвлөмж өгсөн байгаа нь дээрх заалтуудтай нийцэхгүй байна.

Мөн түүнчлэн тайлангийн төсөлд дурдагдсан зарим асуудлуудад дараах тайлбарыг гаргаж байна.

1.Тайлангийн 1.2-т “Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2, 74 дүгээр зүйлийн 74.5-т заасны дагуу шинээр сонгогдсон УИХ-ын гишүүд болон намуудын санал авсан тоо, саналын тоонд эзлэх хувь зэрэг тодорхой үр дүн гарсан байхад УТНТХ-ийн 27 дугаар зүйлийн 27.5, 27.6, 27.7-т заасан томъёогоор төрийн санхүүжилтийг тооцож төлөвлөөгүй байна”, мөн энэ талаар дүгнэлтийн 3-д, зөвлөмжийн 2-т тус тус тусгасан байна. Гэтэл Сонгуулийн ерөнхий хороо нь төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1-д заасан цагалбарт заасан хугацаанд буюу Улсын Их Хурлын ээлжит сонгуулийн үр дүн гараагүй байхад УТНТХ-ийн 27 дугаар зүйлийн 27.1-д заасны дагуу ээлжит сонгуулийн жилийн дараа жилд улс төрийн намуудад олгох төсвийн санхүүжилтийн хязгаарыг тооцоолон дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд суурилсан жилийн төсвийн саналыг хүргүүлсэн болно. Энэхүү зохицуулалт нь зөвхөн ээлжит сонгуультай жилд төсвийн цагалбарт заасан хугацаатай уялдуулан дараа жилд олгох төрийн санхүүжилтийг төсөвт тусгах зорилгоор санхүүжилтийн хязгаарыг тухайн ээлжит сонгуультай жилд 1 удаа тооцоолж төсөвт тусгах зорилготой зохицуулалт юм. Тооцоолол: (Нийт сонгогчийн тоо*Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 0.7 хувь) 2,089,949 * 660,000 * 0.7 = 9,655,564,380”. Иймд хэрэв уг зохицуулалтын дагуу ээлжит сонгуулийн дараа жилийн төсөвт тусгах хязгаарыг төлөвлөх үндэслэлгүй гэж үзвэл холбогдох эрх зүйн орчинд өөрчлөлт оруулах талаар дүгнэлтэд оруулах,

2.Тайлангийн 1.6-д “Үндэсний эвсэл (Монголын Ногоон нам, Монголын

1526040384

Үндэсний Ардчилсан нам)-ийн 2024 оны орлогын хэмжээ болон Үнэн ба Зөв намын татгалзал нь уг санхүүжилтийг олгох нөхцөлийг хангаагүй, хуульд заасан хугацааны хязгаарлалтад хамаарах тул дараагийн Улсын Их Хурлын ээлжит сонгууль хүртэл тус санхүүжилтийг авах эрх үүсэх боломжгүй байна.” гэж дүгнэжээ. Гэтэл УТНТХ-ийн 27 дугаар зүйлийн 27.8, 28 дугаар зүйлийн 28.5, 29 дүгээр зүйлийн 29.5-д заасны дагуу Монголын Ногоон нам, Монголын Үндэсний Ардчилсан нам, Үнэн ба Зөв намуудын орлогын хэмжээ тайлант жилдээ хуулийн шаардлагад хүрсэн, мөн хүсэлт гаргасан тохиолдолд дараагийн УИХ-н ээлжит сонгууль хүртэлх хугацаанд санхүүжилт авах эрхтэй байна. Өөрөөр хэлбэл тухайн жилд тухайн намын орлогын дүнгээс хамаарч төрийн санхүүжилт олгох эсэхийг шийдвэрлэх бөгөөд хэрэв татгалзсан, эсхүл орлого байхгүй тохиолдолд хуулийн 28 дугаар зүйлийн 28.5-д зааснаар тухайн жилд олговол зохих санхүүжилт нь улсын төсөвт үлдэхээр хуульчилсан байна.

3.Тайлангийн 4.3-д “Төрийн санхүүжилт авсан Ардчилсан нам нь хуулийн 26.3.1, 26.3.2-т заасан доод хязгаараас 133.8 сая төгрөг, Иргэний Зориг Ногоон нам нь хуулийн 26.3.1-т заасан хязгаараас 30.1 сая төгрөгийг дутуу зарцуулсан нь хараат бус аудитын хуулийн этгээдийн дүгнэлт, тайлангаар баталгаажсан боловч Сонгуулийн ерөнхий хороо хяналт хэрэгжүүлээгүй байна” гэж дүгнэжээ. Гэтэл Ардчилсан намын санхүүгийн тайланд аудит хийсэн Миндүг аудит ХХК, Иргэний Зориг Ногоон намын санхүүгийн тайланд аудит хийсэн Голден пейж аудит ХХК-ийн дүгнэлт, тайланд хуульд заасан хязгаараас дутуу зарцуулсан гэх тайлбар, зөвлөмж тусгагдаагүй. Сонгуулийн ерөнхий хорооноос хуульд заасан хугацаанд намуудын ирүүлсэн баримтын хүрээнд хяналтын ажлыг хэрэгжүүлэн Ардчилсан нам 2.2 сая төгрөг, Иргэний Зориг Ногоон нам 52.3 сая төгрөгийн анхан шатны баримт дутуу болон зарцуулбал зохих дүнгээс дутуу зарцуулсан талаар тодорхой дүгнэсэн байна.

4.Тайлангийн 5.2-т “Тус байгууллага намын санхүүгийн тайланг хүлээн авч, хяналт тавьж, тодорхой ажлуудыг хэрэгжүүлж ажилласан гэх боловч хяналтын шалгуур үзүүлэлтийг оновчтой тогтоож, илэрсэн зөрчил, дутагдлын шалтгаан, үр дагаварт хангалттай дүн шинжилгээ хийгээгүй, төрийн санхүүжилтийг хуульд заасан зориулалт тус бүрээр хэрэгжилтийг үнэлээгүй байна.” гэж дүгнэсэн байна. Тус Хорооноос намын санхүүгийн тайланд хяналтын ажиллагааг гүйцэтгэхдээ хуульд заасан хугацаанд намаас ирүүлсэн баримтын хэмжээнд илэрсэн алдаа зөрчилд дүн шинжилгээ хийж, төрийн санхүүжилтийг хуульд заасан зориулалт тус бүрээр хэрэгжүүлсэн байдлыг үнэлэн нам тус бүрт дүгнэлт гаргаж, дүгнэлтийг эмхэтгэн хэвлэж ажилласан болохыг үүгээр хүргүүлж байна.

Хүндэтгэсэн,

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ БӨГӨӨД
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



Д.ДАВАА-ОЧИР

Холбогдох байгууллагын саналд өгөх хариу тайлбар

№	Тайлангийн төсөлд ирүүлсэн санал	ҮАГ-ын хариу тайлбар
1	<p>Улс төрийн намын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.4, 39 дүгээр зүйлийн 39.4, 39.5, Сонгуулийн ерөнхий хорооны 2024 оны 209 дүгээр тогтоолоор батлагдсан “Намд төрийн санхүүжилт олгох, шууд бус дэмжлэгийг шийдвэрлэх, намын санхүү болон үйл ажиллагааг тайлагнах, мэдээлэх, хяналт тавих журам”-ын 8 дугаар зүйлийн 8.1, 8.2-т тус тус заасны дагуу Төрийн аудитын байгууллага нь намд олгох төрийн санхүүжилтийг тогтоосон байдал, түүний зарцуулалтад хяналт тавихаар хуульчилсан байна. Гэтэл танай тайлангийн төсөлд Сонгуулийн ерөнхий хорооны хяналтын ажиллагаанд аудит хийж дүгнэлт, зөвлөмж өгсөн байгаа нь дээрх заалтуудтай нийцэхгүй байна.</p>	<p>УТНТ хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3-т зааснаар ТАБ нь сонгуулийн төв байгууллагын төсвийн багцад туссан намд олгох төрийн санхүүжилт, түүний зарцуулалт, тайлагналд нийцлийн аудитыг хийсэн бөгөөд төсвийн хөрөнгийг төлөвлөх, хуваарилах, хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлж буй Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.36, 4.1.38 -т заасан эрх бүхий этгээд болох СЕХ-ны үйл ажиллагаа нь аудитад хамаарна. СЕХ-ны журмаар ТАБ-ын хуулиар олгосон бүрэн эрхийг хязгаарлах үндэслэлгүй тул саналыг хүлээн авах боломжгүй байна.</p>
2	<p>Тайлангийн 1.2-т “Монгол Улсын Их Хурлын санхүүжилтийг тооцож төлөвлөөгүй байна”, мөн энэ талаар дүгнэлтийн 3-д, зөвлөмжийн 2-т тус тус тусгасан байна. Гэтэл Сонгуулийн ерөнхий хороо нь төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1-д заасан цаглабарт заасан хугацаанд буюу Улсын Их Хурлын ээлжит сонгуулийн үр дүн гараагүй байхад УТНТХ-ийн 27 дугаар зүйлийн 27.1-д заасны дагуу ээлжит сонгуулийн жилийн дараа жилд улс төрийн намуудад олгох төсвийн санхүүжилтийн хязгаарыг тооцоолон дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд суурилсан жилийн төсвийн саналыг хүргүүлсэн болно. Энэхүү зохицуулалт нь зөвхөн ээлжит сонгуультай жилд төсвийн цаглабарт заасан хугацаатай уялдуулан дараа жилд олгох төрийн санхүүжилтийг төсөвт тусгах зорилгоор санхүүжилтийн хязгаарыг тухайн ээлжит сонгуультай жилд 1 удаа тооцоолж төсөвт тусгах зорилготой зохицуулалт юм. Тооцоолол: (Нийт сонгогчийн тоо*Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 0.7 хувь) 2,089,949 * 660,000 * 0.7 = 9,655,564,380”. Иймд хэрэв уг зохицуулалтын дагуу ээлжит сонгуулийн дараа жилийн төсөвт тусгах хязгаарыг төлөвлөх үндэслэлгүй гэж үзвэл холбогдох эрх зүйн орчинд өөрчлөлт оруулах талаар дүгнэлтэд оруулах</p>	<p>Төрөөс улс төрийн намд олгох төрийн санхүүжилтийг СЕХ-ны 2024 оны 191 дүгээр тогтоолоор батлагдсан УИХ-ын гишүүнээр сонгогдсонд тооцох тухай шийдвэр болон сонгуулийн үр дүнд үндэслэн бодитой төлөвлөх, Төсвийн тухай хууль болон УТНТ хуульд заасан аргачлалын дагуу боловсруулах талаар зөвлөмж өгсөн. Иймд ойлголтын зөрүү үүсэж байгаа тул дахин найруулж, тайланд өөрчлөлт оруулав.</p>
3	<p>Тайлангийн 1.6-д “Үндэсний эвсэл тус санхүүжилтийг авах эрх үүсэх боломжгүй байна.” гэж дүгнэжээ. Гэтэл УТНТХ-ийн 27 дугаар зүйлийн 27.8, 28 дугаар зүйлийн 28.5, 29 дүгээр зүйлийн 29.5-д заасны дагуу Монголын Ногоон нам, Монголын Үндэсний Ардчилсан нам, Үнэн ба Зөв намуудын орлогын хэмжээ тайлант жилдээ хуулийн шаардлагад хүрсэн, мөн хүсэлт гаргасан тохиолдолд дараагийн УИХ-н ээлжит сонгууль хүртэлх хугацаанд санхүүжилт авах эрхтэй байна. Өөрөөр хэлбэл тухайн жилд тухайн намын орлогын дүнгээс хамаарч төрийн санхүүжилт олгох эсэхийг шийдвэрлэх бөгөөд хэрэв татгалзсан, эсхүл орлого байхгүй тохиолдолд хуулийн 28 дугаар зүйлийн 28.5-д зааснаар тухайн жилд олговол зохих санхүүжилт нь улсын төсөвт үлдэхээр хуульчилсан байна.</p>	<p>СЕХ-ны тайлбарт дурдсанчлан уг санхүүжилт нь УТНТ хуулийн 27 дугаар зүйлийн 27.7-д заасан нэг удаагийн шинжтэй, хугацааны хязгаарлалтад хамаарах тул тухайн нөхцөлд санхүүжилт авах эрх үүсэхгүй талаар тусгасан бөгөөд зөвхөн найруулгыг сайжруулав.</p>

Улс төрийн намд олгосон санхүүжилт, гүйцэтгэлд гаргасан дүгнэлтийг Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэлд нэгтгэн тайлагнах аудитын тайлан

4	<p>Тайлангийн 4.3-д “Төрийн санхүүжилт авсан Сонгуулийн ерөнхий хороо хяналт хэрэгжүүлээгүй байна” гэж дүгнэжээ. Гэтэл Ардчилсан намын санхүүгийн тайланд аудит хийсэн Миндуг аудит ХХК, Иргэний Зориг Ногоон намын санхүүгийн тайланд аудит хийсэн Голден пейж аудит ХХК-ийн дүгнэлт, тайланд хуульд заасан хязгаараас дутуу зарцуулсан гэх тайлбар, зөвлөмж тусгагдаагүй. Сонгуулийн ерөнхий хорооноос хуульд заасан хугацаанд намуудын ирүүлсэн баримтын хүрээнд хяналтын ажлыг хэрэгжүүлэн Ардчилсан нам 2.2 сая төгрөг, Иргэний Зориг Ногоон нам 52.3 сая төгрөгийн анхан шатны баримт дутуу болон зарцуулбал зохих дүнгээс дутуу зарцуулсан талаар тодорхой дүгнэсэн байна.</p>	<p>АХЭ-ийн баталгаажуулсан санхүүгийн тайлан, дүгнэлт болон СЕХ-оос 2026 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн 1/201 дүгээр бичгийн хавсралтаар ирүүлсэн хяналтын ажиллагааны нэгтгэсэн тайланд УТНТ хуулийн 26 дугаар зүйлийн 26.3-т заасан зориулалтаар зарцуулалтын доод хувь хэмжээнд хүрээгүй, дутуу зарцуулсан асуудлыг дүгнээгүй байна. Тайлангийн 4.3-д тусгасан асуудал нь ойлголтын зөрүүтэй байх тул найруулгыг сайжруулав.</p>
5	<p>Тайлангийн 5.2-т “Тус байгууллага намын дүн шинжилгээ хийгээгүй, төрийн санхүүжилтийг хуульд заасан зориулалт тус бүрээр хэрэгжилтийг үнэлээгүй байна.” гэж дүгнэсэн байна. Тус Хорооноос намын санхүүгийн тайланд хяналтын ажиллагааг гүйцэтгэхдээ хуульд заасан хугацаанд намаас ирүүлсэн баримтын хэмжээнд илэрсэн алдаа зөрчилд дүн шинжилгээ хийж, төрийн санхүүжилтийг хуульд заасан зориулалт тус бүрээр хэрэгжүүлсэн байдлыг үнэлэн нам тус бүрт дүгнэлт гаргаж, дүгнэлтийг эмхэтгэн хэвлэж ажилласан болохыг үүгээр хүргүүлж байна.</p>	<p>УТНТ хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2-т заасны дагуу Сонгуулийн төв байгууллага нь тус хуулийн 38 дугаар зүйлийн 38.1 , 39 дүгээр зүйлийн 39.4-т заасан цаглаварт хугацаанд улс төрийн намын үйл ажиллагааны товч тайланг 2026 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 3/187 тоот бичгийн хавсралтаар, СЕХ-ны хяналтын ажиллагааны нэгтгэсэн тайлан болон улс төрийн намуудын аудитласан санхүүгийн тайланг 2026 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн 1/201 тоот бичгийн хавсралтаар тус тус ирүүлснийг аудитад хамруулсан. Аудитын тайлагналын үе шатанд СЕХ-оос 2026 оны 05 дугаар сарын 29-ны өдрийн 1/330 тоот бичгийн хавсралтаар нам тус бүрт дүгнэлт гаргасан эмхэтгэлийг ирүүлсэн тул тайланд өөрчлөлт оруулав.</p>

ХАВСРАЛТ 1

АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ ХҮСНЭГТ

/сая төгрөгөөр/

№	Зөрчлийн утга	Аудитын байгууллагаас гаргасан шийдвэр				Нийт зөрчлийн дүн	
		Албан шаардлага		Зөвлөмж		Зөрчлийн тоо	Мөнгөн дүн
		зөрчлийн тоо	мөнгөн дүн	Зөрчлийн тоо	Мөнгөн дүн		
1	Монгол ардын нам						
1.1	МАН нь төрөөс олгосон санхүүжилтээс 1,408.2 сая төгрөгийн ажиллагсадтай холбоотой зардал буюу цалинд зарцуулж зориулалт бусаар зарцуулсан байна.			1	1,408.2	1	1,408.2
1.2	МАН нь хуулийн 26.3.1-26.3.3 дахь заалтад тайлагнасан 1,411.6 сая төгрөгийн зарцуулалтаас нийт 51.6 сая төгрөгийг анхан шатны баримтгүй, зориулалт бус зарцуулсан байна.	1	51.6			1	51.6
1.3	МАН нь хуулийн 26.3.1-26.3.3 дахь заалтад тайлагнасан 1,411.6 сая төгрөгийн зарцуулалтаас 334.2 сая төгрөгийн зардлыг цахим баримтаар бүрэн баталгаажуулаагүй, зардлын гүйлгээг бэлэн мөнгөний дансаар хэрэгжүүлсэн, анхан шатны баримтын бүрдэл хангаагүй, хүчингүй маягтаар тайлагнаж, татварын нэгдсэн цахим системд бүртгээгүй байна.			1	334.2	1	334.2
	Дүн	1	51.6	2	1,742.4	3	1,794.0
2	Ардчилсан нам						
2.1	Ардчилсан нам нь Улс төрийн намд олгох Төрийн санхүүжилтээс үндсэн үйл ажиллагаанд буюу намын ажилчдын цалин хөлс 537.1 сая төгрөг, нийгмийн даатгалын шимтгэл 127.9 сая төгрөг, хүн амын орлогын албан татвар 35.4 сая, харилцаа холбоо, интернэт 22.2 сая төгрөг, бичиг хэрэг 1.6 сая төгрөг, төлбөр хураамж 3.3 сая төгрөг, албан томилолт 11.7 сая төгрөг, санхүүгийн зөвлөх мэргэжлийн үйлчилгээ 16.1 сая төгрөг, хэвлэл сурталчилгаа 2.4 сая төгрөг, ашиглалтын зардалд 0.7 сая төгрөг, нийт 758.4 сая төгрөгийг зарцуулсан байна.			1	758.4	1	758.4
2.2	Ардчилсан намын аудитлагдсан тайлангаар төрийн санхүүжилтийн 20-оос доошгүй хувийг эмэгтэй, ахмад, залуу, хөгжлийн бэрхшээлтэй иргэд зэрэг нийгмийн бүлгүүдийн улс төрийн оролцоог дэмжих, сургаж бэлтгэхэд зориулж 312,9 сая төгрөг, 15-аас доошгүй хувийг намын гишүүдийн болон иргэдийн улс төрийн боловсролыг дээшлүүлэх, ардчилал, хүний эрхийн үнэт зүйлийг нийтэд таниулахад зориулж 313.9 сая төгрөг, нийт 626.8 сая төгрөгийг зарцуулсан бөгөөд энэ нь тус зориулалтын дагуу зарцуулах хамгийн доод хязгаар болох 15.0 хувь болон 20.0 хувьд хүргэлгүй 133.8 сая төгрөгийг үйл ажиллагааны зардалд зориулалт бусаар зарцуулсан байна.			1	133.8	1	133.8
2.3	Ардчилсан намын их хурлын зохион байгуулж, шилдэг сумын намын хороонуудад 25 ширхэг нөүтбүүкийг шагнал, урамшуулал болгон өгсөн нь анхан шатны бүрдэлгүй, зориулалт бус байна.			1	50.0	1	50.0
	Дүн			3	942.2	3	942.2
3	ХҮН нам						
3.1	ХҮН нам нь төрөөс олгосон санхүүжилтээс 34.5 сая төгрөгийг цалин хөлс, 12.0 сая төгрөгийг нийгмийн даатгалын шимтгэл төлөхөд, 109.5 сая төгрөгийг түрээс, 8.3 сая төгрөгийг шуудан холбоо, интернэт, 65.8 сая төгрөгийг үндсэн хөрөнгө худалдан авахад, 22.8 сая төгрөгийг вебийн төлбөрт нийт 252.9 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.			1	252.9	1	252.9
3.2	Төрөөс олгосон санхүүжилтээс намын 10 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэхэд 174.9 сая төгрөгийг зарцуулсан байна.			1	174.9	1	174.9
3.3	Төрөөс олгосон санхүүжилтээс компьютер, принтер, тавилга эд хогшил, биет бус хөрөнгө олж бэлтгэхэд 65.8 сая төгрөгийг зарцуулсан байна.			1	65.9	1	65.9

Улс төрийн намд олгосон санхүүжилт, гүйцэтгэлд гаргасан дүгнэлтийг Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэлд нэгтгэн тайлагнах аудитын тайлан

3.4	Хуулийн 26.3.1-д хамаарах зардалд тайлагнасан 199.6 сая төгрөгийн зардлаас Модель энд фэйшн индастри менежмент ХХК-аас 15.0 сая төгрөгийн урлагийн үйлчилгээ, Дөлгөөн Ганбат гэдэг хүнээс 9.6 сая төгрөгийн шинэ жилийн хүлээн авалтын бэлэг худалдан авч, нийт 24.6 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.	1	24.6			1	24.6
3.5	Хуулийн 26.3.2-д хамаарах зардалд тайлагнасан 150.6 сая төгрөгийн зардлаас намын дарга, ЕНБД, ажлын алба, намын үндсэн болон дэмжигч гишүүдтэй үндэсний баяр наадмыг тохиолдуулан хүндэтгэлийн хүлээн авалт, уулзалт хийхэд 19.5 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.	1	19.5			1	19.5
3.6	ХҮН намын дэргэд "ХҮН" бодлого судалгааны төвийг 2025 оны 10 дугаар сард байгуулсан бөгөөд тайлант онд 50.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгож, 116.6 сая төгрөгийг дутуу олгосон байна. Намын бодлогын судалгааны байгууллагын үйл ажиллагаанд 26.3.1-26.3.3 дахь хэсэгт заасан зорилтот санхүүжилт тус бүрийн гуравны нэгээс доошгүйг намын бодлогын судалгааны байгууллагын үйл ажиллагаанд зарцуулаагүй байна.				1	116.7	116.7
Дүн		2	44.1	4	610.4	6	654.5
4	Иргэний Зориг Ногоон нам						
4.1	Иргэний Зориг Ногоон Нам нь тайлант онд төрийн санхүүжилтийн эх үүсвэрээс 62.1 сая төгрөгийг ажиллагсдын цалингийн зардалд, 54.1 сая төгрөгийн түрээсийн зардалд, 0.5 сая төгрөгийг тээврийн зардалд, 5.4 сая төгрөгийг хангамжийн зардалд, 0.5 сая төгрөгийг бичиг хэргийн зардалд, 62.8 сая төгрөгийг мэргэжлийн үйлчилгээний зардалд зарцуулсан байна.				1	185.4	185.4
4.2	Иргэний Зориг Ногоон Нам нь төрийн санхүүжилтийн 20-оос доошгүй хувийг эмэгтэй, ахмад, залуу, хөгжлийн бэрхшээлтэй иргэд зэрэг нийгмийн бүлгүүдийн улс төрийн оролцоог дэмжих, сургаж бэлтгэхэд зориулж 61.0 сая төгрөгийг зарцуулсан бөгөөд энэ нь тус зориулалтын дагуу зарцуулах хамгийн доод хязгаар болох 20 хувьд хүрээгүй, 30.1 сая төгрөгийг үйл ажиллагааны зардалд зарцуулсан байна.				1	30.1	30.1
4.3	Тус нам нь тайлант онд төрийн санхүүжилтийн эх үүсвэрээс 9.9 сая төгрөгийн зардлыг анхан шатны баримтгүй, зарцуулсан байна.	1	9.9			1	9.9
4.4	Нэр бүхий 2 аж ахуйн нэгж байгууллагатай аппликейшн бүтээлгэх, хөгжүүлэлт хийлгэх гэрээ байгуулж, 46.0 сая төгрөгийн төлбөрийг төрийн санхүүжилтийн эх үүсвэрээс олгосон байна. Гэвч төрийн санхүүжилтээр зөвхөн тухайн тайлант хугацаанд зардлаар хүлээн зөвшөөрөх ажил, үйлчилгээг санхүүжүүлэхээр хууль тогтоомжид зохицуулсан байна. Мөн аппликейшний хөгжүүлэлт нь байгууллагын программ хангамжийн хүчин чадал, үйл ажиллагааны модулийг нэмэгдүүлэх зориулалттай бөгөөд ирээдүйд эдийн засгийн өгөөж бий болгох шинжтэй, тусдаа танигдах боломжтой хөрөнгөд хамаарч байна. Иймд энэхүү зардал нь НББОУС 31 "Биет бус хөрөнгө"-д заасан шалгуурыг хангаж байгаа тул тайлант үеийн зардлаар бус, биет бус хөрөнгийн өртөгт капиталжуулах, өртөгт оруулан тооцох зардалд хамаарахаар байна.				1	46.0	46.0
Дүн		1	9.9	3	261.5	4	271.4
5	Монголын Ногоон Нам						
5.1	Монголын Ногоон Нам нь төрийн санхүүжилтийн эх үүсвэрээр үндсэн үйл ажиллагаа буюу гэрээгээр ажил гүйцэтгүүлэхэд 19.4 сая төгрөгийг зарцуулсан байна.				1	19.4	19.4
5.2	Монголын Ногоон Нам нь 2 хуулийн этгээдтэй Сургалт хөгжлийн үйлчилгээ үзүүлэх, Медиа Контент бэлтгэл болон хэвлэлийн үйлчилгээний гэрээ байгуулж, төрөөс олгосон санхүүжилтээс 61.5 сая төгрөгийг зарцуулсан боловч намын дүрмийг хуульд нийцүүлэн шинэчилж байгаа гэсэн шалтгаанаар сургалтыг зохион байгуулаагүй, контентын зохиол, найруулгыг гүйцэтгэгч байгууллагад хүргүүлээгүй тул гэрээний хэрэгжилтийг үнэлэх боломжгүй байна. Тус гэрээний дуусгавар болох эцсийн хугацаа 2026.08.12 байна.	1	61.5			1	61.5
5.3	Аж ахуйн нэгжтэй аппликейшний хийлгэх гэрээ байгуулж, 60.0 сая төгрөгийн урьдчилгаа төлбөрийг төрийн санхүүжилтийн эх үүсвэрээс олгосон нь НББОУС 31 "Биет бус хөрөнгө"-д заасан шалгуурыг хангаж байгаа тул төрийн санхүүжилтээр хөрөнгө олж бэлтгэхгүй байх журмын зүйл заалтыг зөрчсөн байна.				1	60.0	60.0
Дүн		1	61.5	2	79.4	3	140.9
6	Монголын Үндэсний Ардчилсан Нам						
6.1	Монголын үндэсний ардчилсан намд төрөөс 24.4 сая төгрөгийн санхүүжилтийг анхан шатны баримтын бүрдэлгүй зарцуулсан байна.	1	24.4			1	24.4

Улс төрийн намд олгосон санхүүжилт, гүйцэтгэлд гаргасан дүгнэлтийг Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэлд нэгтгэн тайлагнах аудитын тайлан

Дүн		1	24.4			1	24.4
7	Шинэ Нам						
7.1	Шинэ нам нь үндсэн үйл ажиллагаанд улс төрийн намд олгох төрийн санхүүжилтээс намын ажилчдын цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл 36.6 сая төгрөг, түлш, шатахуун тээврийн зардалд 1.3 сая төгрөг, харилцаа холбоо 0.7 сая төгрөг, бичиг хэргийн зардал, компьютер дагалдах хэрэгсэл 14.0 сая төгрөг, гэрээт ажлын зардал/түрээс 48.0 сая төгрөг, ашиглалтын зардал 5.4 сая төгрөг, хангамжийн зардал 1.4 сая төгрөг, нийт 107.6 сая төгрөгийг зарцуулсан байна.			1	107.6	1	107.6
7.2	Намын гишүүдийн уулзалт, ажлын хэрэгцээнд 5 удаагийн бэлэн тооцоогоор 2.6 сая төгрөгийг гаргаж, хоол, цай, чихэр, вино гэсэн хүнсэнд зарцуулсан байгаа нь зориулалт бус байна.			1	2.6	1	2.6
7.3	Шинэ нэгдсэн эвслийн Удирдах зөвлөлийн 2024 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн 05 дугаар тогтоолоор эвслийн гэрээний хавсралтад заасны дагуу нэр дэвшигчийн тоонд үндэслэн нийт сонгогчдоос авсан саналд ногдох төрийн санхүүжилтийг 80:20 харьцаагаар хуваарилахаар тохиролцсон байна. Гэвч эвсэлд нэгдсэн Монголын Уламжлалын Нэгдсэн нам нь төрийн санхүүжилт авах хуульд заасан шаардлагыг хангаагүй тул эвслийн гэрээний хавсралтад өөрчлөлт оруулж, тухайн намд ногдох төрийн санхүүжилтийн хувийг Шинэ намд 100.0 хувь шилжүүлэхээр шийдвэрлэсэн байна. Улс төрийн намын тухай хуульд эвслийн гэрээ, түүний хүрээнд төрийн санхүүжилтийг хуваарилахтай холбоотой нарийвчилсан зохицуулалт, хязгаарлалт тодорхой тусгагдаагүй байгаа нь эвсэлд нэгдсэн намууд төрийн санхүүжилтийг бүрэн авах зорилгоор хуульд заасан шаардлага хангаагүй, орлогын босгод хүрээгүй намын оролцоог ашиглах нөхцөл бүрдүүлж болзошгүй байна.			1	46.0	1	46.0
7.4	Шинэ нам нь нийтийн мэдээллийн ил тод байдлыг ханган ажиллаагүй, цахим мэдээллийн сайтад үйл ажиллагааны тайлан, санхүүгийн хагас бүтэн жилийн тайлан, аудитын дүгнэлт, төсөв төлөвлөгөө, төрийн санхүүжилт, зарцуулалтын талаар мэдээлэл оруулаагүй байна.			1		1	
7.5	Шинэ нэгдсэн эвсэл нь төрийн санхүүжилт авч, зарцуулалтыг журамд заасны дагуу зохион байгуулсан үйл ажиллагаа тус бүрээр тайлагнаагүй байна.			1		1	
Дүн				5	156.2	5	156.2
8	Сонгуулийн Ерөнхий Хороо						
8.1	Улс төрийн намын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3, 26.4-т заасан улс төрийн намд олгох төрийн санхүүжилтийн зарцуулалтыг зарцуулах хувь, зардлын ангилал, шалгуур үзүүлэлт, бүртгэл тайлагнал тодорхойгүй, журмын зүйл заалт, батлагдсан маягт хуульд нийцэхгүй байна.			1		1	
8.2	Улс төрийн намд олгосон төрийн санхүүжилтийн зарцуулалтын анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй, цахим төлбөрийн баримтад үндэслэн ажил гүйлгээг бүртгэж тайлагнаагүй байна.			1		1	
8.3	Төрийн санхүүжилт авч байгаа нам, эвсэл төрийн санхүүжилтийн төсөв, зарлага, санхүүжилтийн мэдээлэл, тайланг жил бүр шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулаагүй, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаагүй байна.			1		1	
Дүн				3		3	
Нийт дүн		6	191.5	22	3,792.1	28	3,983.6



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 06 сарын 09 өдөр

Дугаар 1484/АД111371

Улаанбаатар хот

САГ-2026/03/ШТА-НА

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд хийсэн "Улс төрийн намд олгосон санхүүжилт, гүйцэтгэлд гаргасан дүгнэлтийг Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэлд нэгтгэн тайлагнах аудитын тайлан" аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Улс төрийн намд олгосон төрийн санхүүжилтээс хавсралтад дурдсан намууд нийт 191,581,767.00 (нэг зуун ерэн нэгэн сая таван зуун наян нэгэн мянга долоон зуун жаран долоо) төгрөгийг анхан шатны баримтгүй, гэрээний хэрэгжилт хангаагүй, зориулалт бус зарцуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "Үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Улс төрийн намын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.5-д "Энэ хуулийн 26.3-т заасан санхүүжилтийг тухайн зорилгоос өөр зориулалтаар зарцуулахыг хориглоно", 31 дүгээр зүйлийн 31.1-д "Сонгуулийн төв байгууллага төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэг, түүний зарцуулалтын тайланг хянаж, хүлээн авч нэгтгэн тайлагнана.", 36 дугаар зүйлийн 36.2-д "Нам санхүүгийн тайлангаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон энэ хуульд заасан шаардлагын дагуу гаргана", 36.4-д "Зардалд дараах зүйлийг бүртгэнэ", 36.4.3-д "энэ хуулийн 26.3.1-д заасан үйл ажиллагааны зардал", 36.4.4-д "энэ хуулийн 26.3.2-д заасан үйл ажиллагааны зардал", 36.4.5-д "энэ хуулийн 26.3.3-т заасан үйл ажиллагааны зардал", 36.4.6-д "энэ хуулийн 36.4.3, 36.4.4, 36.4.5-д зааснаас бусад үйл ажиллагааны зардал", Сангийн сайд, Сонгуулийн ерөнхий хорооны 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн А/243, 208 дугаар хамтарсан тушаал, тогтоолын хавсралтаар батлагдсан "Улс төрийн намын санхүүгийн тайлангийн бүтэц, тайлагнах журам"-ын 5 дугаар бүлгийн 5.3.5-д "Төрийн санхүүжилтийн зарцуулалтыг зохион байгуулсан үйл ажиллагаа тус бүрээр тайлагнана" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**


1. Анхан шатны баримтгүй, зориулалт бусаар зарцуулдаг, гэрээний үүргийн хэрэгжилт хангагдаагүй зэрэг нийт 191,581,767.00 (нэг зуун ерэн нэгэн сая таван зуун наян нэгэн мянга долоон зуун жаран долоо) төгрөгийн зөрчлийг арилгаж, хяналт хэрэгжүүлэн, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Сонгуулийн ерөнхий хорооны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Даваа-Очир), Улс төрийн намын санхүүжилт, хяналтын газрын дарга (Н.Булгамаа) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



С.МАГНАЙСҮРЭН

Үндэсний аудитын газрын 2026 оны 06
дугаар сарын 09-ны өдрийн 1484
дугаар албан шаардлагын хавсралт



Улс төрийн намд олгосон санхүүжилт, гүйцэтгэлд гаргасан дүгнэлтийг
Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэлд нэгтгэн тайлагнах аудитаар төрөөс олгосон
санхүүжилтээс зориулалтын дагуу зарцуулаагүй улс төрийн намуудын жагсаалт

/төгрөгөөр/

№	Намын нэр	Дүн
1	Монгол Ардын нам	51,604,569.00
2	ХҮН нам	44,129,000.00
3	Иргэний зориг ногоон нам	9,931,200.00
4	Монголын Ногоон нам	61,500,000.00
5	Монголын Үндэсний Ардчилсан нам	24,416,998.00
	Нийт дүн	191,581,767.00